

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

«XXI ЗУУНЫ ЗҮҮН ХОЙТ АЗИ» СЭДЭВТ ОЛОН
УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ

Д. Баясгалан*

1995 оны 7-р сарын 18—20-ны өдрүүдэд БНХАУ-ын Ляонин мужийн Шэньян хотод Ляонины их сургууль болон БНСУ-ын Кюньхн их сургуулиас хамтран уг хурлыг зохион байгуулж явууллаа. Эрдэм шинжилгээний бага хуралд БНАСАУ, БНСУ, БНХАУ, Япон, Тайвань, Монгол, Гонконгийн 40 гаруй судлаач эрдэмтэд оролцож санал бодлоо солилцов.

Бага хурлын нээлт, хаалтын ёслолд зориулж Ляонины их сургуулийн захирал Ма бао жун үг хэлэв. Гурван бүтэн өдөр үргэлжилсэн энэхүү хуралд оролцогсод XXI зууны Ази тив дэлхийн хөгжлийг тэргүүлэх болж байгааг онцлон тэмдэглээд улмаар шинэ зууны хөгжил дэвшлийг манлайлах Зүүн хойт Азийн нийгэм, улс төр, соёлын асуудлуудыг хөндөн хэлэлцэв. Мөн энэхүү бүс нутгийн орнуудын харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааны асуудлууд болон Түмэн голыг хамтран ашиглах тухайд ихээхэн анхаарал хандууллаа.

Уг бага хуралд манай төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор Д. Баясгалан оролцож «Зүүн хойт Азийн орнуудын хамтын ажиллагаан дахь Монголын гадаад бодлого» илтгэлийг тавьж хэлэлцүүлэв. Илтгэлтэй холбогдуулан Хятад, Солонгосын эрдэмтэд үг хэлж, өнөөгийн Монгол орны зах зээлийн хөгжлийн явц, нээлттэй бодлогын давуу тал, Түмэн голын төслийг Монгол улс дэмжин энэ ажиллагаанд идэвхитэй оролцож байгааг талархан тэмдэглэлээ.

Зүүн хойт Азийн асуудлаар жил бүр БНХАУ-ын Чанчунь, Шэньян, Харбин хотуудад болж байгаа олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ач холбогдлыг төлөөлөгчид өндрөөр үнэлж байв.

Энэ удаагийн «XXI зууны Зүүн хойт Ази» эрдэм шинжилгээний бага хурал нь тухайн бүс нутгийн орнуудын төрийн дээд хэмжээний уулзалтын өмнө судлаач эрдэмтдийн хүрээнд болж олон асуудлуудыг хэлэлцэн санал бодлоо солилцсоноороо чухал ач холбогдолтой болов.

* Д. Баясгалан. Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор

ЭМГЭНЭЛ

ГҮНЖИЙН СҮХБААТАР

Монгол Улсын ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын Төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, «Зүүн хойт Ази судлал» сэтгүүлийн эрхлэгч, нэрт эрдэмтэн, түүхийн ухааны доктор, сурган хүмүүжүүлэгч Гүнжийн Сүхбаатар 1995 оны наймдугаар сарын 29-нд 67 насандаа зуурдаар нас нөгчин, монголын шинжлэх ухаан, боловсролын салбарт том гарз тохиолдлоо.

Г. Сүхбаатар 1928 онд Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт төржээ. 1952 онд МУИС-ийг төгссөнөөс хойш МАХН-ын Төв Хороо, Намын түүхийн институт, Улсын их сургууль, Холбооны сургалтын төв, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Дорно дахины судлалын хүрээлэн, Зүүн хойт Ази судлалын төв зэрэг сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудад тасралтгүй 40 гаруй жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж ирсэн юм.

Г. Сүхбаатар амьдралынхаа 30 гаруй жилийг Монголын эртний түүхийн судалгааны ажилд зориулж «Сүмбэ», «Монголчуудын эртний өвөг», «Монгол Нирун улс» зэрэг нэгэн сэдэвт зохиолууд туурвиж, хүннү, сүмбэ нар нь эртний Монгол угсаатан мөн, нирун нь язгуур монголчууд мөн болохыг олон талаас нотлон харуулж, язгуур монголчуудын түүхийг шинэ санаа дүгнэлтүүдээр баяжуулан, түүний үечлэлийг олон зуун жилээр урагшлуулсан нээлт хийсэн юм. Монголын түүхийн шинжлэх ухаанд оруулсан Г. Сүхбаатарын энэхүү нээлтийг дотосд, гадаадын түүхчид, томоохон эрдэмтэд өндрөөр үнэлдэг юм. Тэрбээр Монголын түүхийн үндсэн ботиудын зохиогчдын нэг байлаа.

Г. Сүхбаатар шинжлэх ухааны шударга зарчмыг хатуу баримталж, олон орны судлаачид ялангуяа орос, зөвлөлтийн түүхчид онолчдын шинжилгээний бүтээл туурвилтай байнга ташилцан, өөрийн судалгааг дэлхийн төвшинд хүргэн явуулж ирсэн эрдэмтэн байв.

Г. Сүхбаатар сурвалж бичгийн нарийвчилсан судалгааг онолын гүнзгий үндэслэлтэй хослуулсны үрээр орчин үеийн монголын түүхийн өргөн хүрээтэй олон асуудлыг ул үндэстэй зоригтой дэвшүүлэн тавьдаг байсан билээ.

Г. Сүхбаатар хойч үеэ боловсрол хүмүүжилтэй болгоход ихээхэн анхаарч, их, дээд сургуулиудад тасралтгүй багшилж, сурах бичиг зохиож ирсэн хичээл зүтгэлтэй сурган хүмүүжүүлэгч, орчуулагч, соён гийгүүлэгч байсан юм.

Төр засаг, эрдэм шинжилгээний байгууллага түүний монголын түүхийн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, ойн медалиуд, ШУА-ийн шагнал хүртээсэн юм.

Г. Сүхбаатар ухамсарт амьдралаа төрөлх эх орон Монгол улсынхаа тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөө зориулсан тууштай эх оронч, гүнзгий сэтгэгч эрдэмтэн-түүхч, манай ахмад сурган хүмүүжүүлэгч, шилдэг сэхээтний нэг байлаа.

Талийгаачийн нэр их хөдөлмөрч, ажилч хичээнгүй, үбэнч шударга, нөхөрсөг даруу, хүчлэг тусч зан чанар, гэгээн дүр бидний сэтгэл зүрхэнд үүрд орших болно.

ЗҮҮН ХОЙТ АЗИ СУДЛАЛЫН ТӨВИЙН
ЭРДМИЙН ХАМТ ОЛОН